

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Зүүн цагаан дэл уурхайн цахилгаан хангамж**

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112456

**“Монголросцветмет”ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **“Зүүн цагаан дэл уурхайн цахилгаан хангамж”** ажлыг нийлүүлэх, гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50 000 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-ийн борлуулалтын орлогын дундаж нь 500 сая төгрөгөөс багагүй,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 500 сая төгрөгөөс багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2020 он

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Шаардлагатай. Эрчим хүчний барилга байгууламж барих-агаарын шугам, дэд өртөө

Тендерийн хамт 10 650 000.00 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 10:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр авч болох бөгөөд тендерийн тодруулгыг Захиалагч [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.